



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/17/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа .....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захиадал .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16



## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 204

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНГӨНЧИМЭГ  
ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Булган сумын Засаг даргын Тамгын газар 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 87.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,422,686.74</b>	<b>148,187,860.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	433,988.00	10,177,895.00
3351	Байгууллагаас авах авлага	433,988.00	10,177,895.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	148,988,698.74	138,009,965.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,205,774.74	14,227,041.00
35420	Аж ахуйн материал	5,349,973.74	841,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	18,855,801.00	13,385,991.00
35600	Мал амьтад	123,782,924.00	123,782,924.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>774,263,817.88</b>	<b>848,202,768.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	774,263,817.88	848,202,768.21
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	767,101,017.88	841,309,493.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	464,678,190.61	464,678,190.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8,989,391.17)	(16,526,076.49)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,085,824.00	106,854,934.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,772,624.16)	(65,310,090.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,858,818.05	102,279,438.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,631,048.25)	(57,538,595.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,426,484.00	57,046,384.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,711,677.40)	(35,880,696.12)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,339,400.00	1,339,400.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	(1,339,400.00)	(1,339,400.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	285,411,481.33	398,530,789.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	(87,255,039.13)	(112,824,784.33)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,162,800.00	6,893,274.96
39301	Програм хангамж	2,898,200.00	2,898,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,507,000.00)	(1,776,525.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,771,600.00	5,771,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>923,686,504.62</b>	<b>996,390,628.21</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>10,177,895.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	10,177,895.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	10,177,895.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,769,390.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,408,505.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>923,686,504.62</b>	<b>986,212,733.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	923,686,504.62	986,212,733.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	581,162,917.26	581,162,917.26
51101	Өмч: - төрийн	581,162,917.26	581,162,917.26
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	234,257,504.65	296,783,733.24
51210	Өмнөх үеийн үр дүн	234,257,504.65	234,257,504.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	62,526,228.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,266,082.71	108,266,082.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>923,686,504.62</b>	<b>996,390,628.21</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>643,186,423.00</b>	<b>534,403,935.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>186,599,949.00</b>	<b>112,371,938.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	186,599,949.00	112,371,938.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,599,949.00	111,476,438.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,500.00	159,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	186,491,449.00	111,316,938.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		895,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>456,586,474.00</b>	<b>422,031,997.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	71,409,574.00	23,699,897.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	354,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,141,989.00	23,345,897.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон хөрөнгө	10,267,585.00	-
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	385,176,900.00	398,332,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	385,176,900.00	398,332,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>510,608,069.49</b>	<b>471,793,706.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>485,408,069.49</b>	<b>449,857,376.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	437,517,996.13	411,755,143.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	215,186,079.64	247,173,010.50
210101	Үндсэн цалин	215,186,079.64	247,173,010.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,233,770.00	31,541,369.00
210201	Тэтгэврийн даатгал	17,134,270.00	21,032,869.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,819,600.00	2,527,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,900.00	2,201,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,300.00	525,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,549,700.00	5,254,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,735,333.00	4,002,869.00
210301	Гэрэл, цахилгаан	1,448,689.00	1,756,628.00
210302	Түлш, халаалт	3,087,644.00	2,246,241.00
210303	Цэвэр, бохир ус	199,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,604,852.00	41,610,528.74
210401	Бичиг хэрэг	5,846,550.00	4,693,100.00
210402	Тээвэр, шатахуун	15,895,792.00	17,785,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,525,000.00	1,223,500.00
210404	Ном, хэвлэл	303,500.00	284,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	184,010.00	249,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	850,000.00	499,700.00
210408	Бараа материал аргасны зардал	-	16,874,233.74
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,525,000.00	3,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,525,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,225,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	299,900.00	-
210604	Урсгал засвар	3,925,100.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,875,500.00	1,589,000.00
210702	Дотоод албан томилолт	7,875,500.00	1,589,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,693,492.00	1,363,812.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	88,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	285,000.00	308,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,492.00	250,292.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	1,398,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	148,438,969.49	81,474,554.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,436,774.00	27,380,567.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	73,002,195.49	54,093,987.67



**Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,890,073.36	38,102,232.50
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,984,700.00	20,007,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,284,700.00	19,897,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	110,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	31,905,373.36	18,094,732.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,905,373.36	18,094,732.50
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,200,000.00</b>	<b>21,936,330.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	25,200,000.00	21,936,330.00
223001	Бусад хөрөнгө	25,200,000.00	21,936,330.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>132,578,353.51</b>	<b>62,610,228.59</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,579,285.24	84,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,579,285.24	84,000.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	1,579,285.24	84,000.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>130,999,068.27</b>	<b>62,526,228.59</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>456,694,974.00</b>	<b>431,394,875.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>108,500.00</b>	<b>593,488.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	108,500.00	593,488.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	108,500.00	593,488.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	108,500.00	159,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	433,988.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>456,586,474.00</b>	<b>430,801,387.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	71,409,574.00	32,469,287.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	354,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,141,989.00	32,115,287.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,267,585.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	385,176,900.00	398,332,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	385,176,900.00	398,332,100.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>428,594,974.00</b>	<b>385,508,485.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>428,594,974.00</b>	<b>385,508,485.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>380,704,900.64</b>	<b>347,406,252.50</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	215,186,079.64	247,173,010.50
210101	Үндсэн цалин	215,186,079.64	247,173,010.50
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,233,770.00	31,541,369.00
210201	Тэтгэврийн даатгал	17,134,270.00	21,032,869.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,819,600.00	2,527,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,274,900.00	2,201,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,300.00	525,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,549,700.00	5,254,300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,570,909.00	4,002,869.00
210301	Гэрэл, цахилгаан	1,448,689.00	1,756,628.00
210302	Түлш, халаалт	2,923,220.00	2,246,241.00
210303	Цэвэр, бохир ус	199,000.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,205,976.00	21,736,295.00
210401	Бичиг хэрэг	5,175,020.00	4,693,100.00
210402	Тээвэр, шатахуун	15,656,656.00	14,785,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,525,000.00	1,223,500.00
210404	Ном, хэвлэл	303,500.00	284,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	275,900.00	249,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,269,900.00	499,700.00
2105	<b>Нормативт зардал</b>	1,525,000.00	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,525,000.00	8,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,480,000.00	-
210601	Багаж, техник хэрэгсэл	8,644,900.00	-
210604	Урсгал засвар	3,835,100.00	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,875,500.00	1,589,000.00
210702	Дотоод албан томилолт	7,875,500.00	1,589,000.00



**Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,207,692.00	1,363,812.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	285,000.00	308,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	245,492.00	250,292.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,514,200.00	-
210807	Газрын төлбөр	1,398,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	76,419,974.00	31,999,897.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,419,974.00	31,999,897.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,890,073.36</b>	<b>38,102,232.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,984,700.00	20,007,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,284,700.00	19,897,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	110,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	31,905,373.36	18,094,732.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,905,373.36	18,094,732.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>28,100,000.00</b>	<b>45,886,390.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>28,100,000.00</b>	<b>45,886,390.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>28,100,000.00</b>	<b>45,886,390.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	28,100,000.00	45,886,390.00
223001	Бусад хөрөнгө	28,100,000.00	45,886,390.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>28,100,000.00</b>	<b>45,886,390.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	234,257,504.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	234,257,504.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	234,257,504.65
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	234,257,504.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	234,257,504.65	234,257,504.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	62,526,228.59	62,526,228.59
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	581,162,917.26	108,266,082.71	296,783,733.24	296,783,733.24



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	396,348,600.00	396,175,588.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	357,081,600.00	361,558,588.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	336,884,100.00	323,706,355.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	252,240,300.00	247,173,010.50
210101	Үндсэн цалин	252,240,300.00	247,173,010.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,506,300.00	31,541,369.00
210201	Тэтгэврийн даатгал	23,164,200.00	21,032,869.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,068,100.00	2,527,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,585,500.00	2,201,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	516,100.00	525,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,172,400.00	5,254,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,400,000.00	4,002,869.00
210301	Гэрэл, цахилгаан	1,800,000.00	1,756,628.00
210302	Түлш, халаалт	2,600,000.00	2,246,241.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,055,300.00	21,736,295.00
210401	Бичиг хэрэг	5,505,000.00	4,693,100.00
210402	Тээвэр, шатахуун	16,950,300.00	14,785,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,223,500.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	284,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутг	300,000.00	249,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	499,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,000,000.00	8,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00	8,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,990,600.00	1,589,000.00
210702	Дотоод албан томилолт	1,990,600.00	1,589,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур</b>	1,691,600.00	1,363,812.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	300,000.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	308,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,000.00	250,292.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	72,600.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,000,000.00	8,300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	8,300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,197,500.00	37,852,232.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,197,500.00	37,852,232.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,897,500.00	19,897,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		17,844,732.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	110,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>39,267,000.00</b>	<b>37,117,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	39,267,000.00	37,117,000.00
223001	Бусад хөрөнгө	39,267,000.00	37,117,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32,469,287.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,469,287.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	23,699,897.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,699,897.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,699,897.00
213209	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,769,390.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Мөнгөнчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 09-нөөс 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Засаг Даргын Тамгын газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3/44 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Булган сумын Засаг Даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Булган сумын Засаг Даргын Тамгын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Булган сумын Засаг Даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 471,793.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 9,435.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,704.1 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	434.0	10,177.9	9,743.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	148,988.7	138,010.0	-10,978.7
Үндсэн хөрөнгө	774,263.8	848,202.8	73,939.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>923,686.5</b>	<b>996,390.6</b>	<b>72,704.1</b>
Өр төлбөр		10,177.9	10,177.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	923,686.5	986,212.7	62,526.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>923,686.5</b>	<b>996,390.6</b>	<b>72,704.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 10,177.9 мянган төгрөг болж өссөн нь худалдан борлуулсан хорголжин тэжээлийн үнэ, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцоноос шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 10,177.9 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 138,010.0 мянган төгрөг болж 10,978.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 848,202.8 мянган төгрөг болж өссөн нь сумын ИТХ-ын тогтоолоор балансаас балансад тээврийн хэрэгсэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бусад хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 111,316.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 16,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор, 20,800.0 мянган төгрөгийн балансаас балансад тээврийн хэрэгсэл шилжүүлэн авснаар тус тус нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталан 1,988.0 мянган төгрөгийн, балансаас балансад 24,000.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлснээр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 10,177.9 мянган төгрөг болж өссөн нь худалдан борлуулсан хорголжин тэжээлийн үнийг холбогдох байгууллагад шилжүүлээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаас ХХОАТ суутган тооцоноос шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 986,212.7 мянган төгрөг болж 62,526.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Булган сумын Засаг Даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 108,782.3 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 38,814.4 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 396,548.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 396,548.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 396,548.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 396,548.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 396,548.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 396,548.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 396,548.6 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 32,469.3 мянган төгрөгийн орлогыг авч 23,700.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал зарцуулан, 8,769.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 3 мэдээлэл, хугацаа хоцроон байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 орлогын 13,680.0 мянган төгрөгийн, 4 зарлагын 37,514.5 мянган төгрөгийн гүйлгээг, 9 хөрөнгийн 149,869.3 мянган төгрөгийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 75,544.6 мянган төгрөгийн зөрчилд 66,066.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 9,478.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-			
Албан шаардлага	3	66,066.0	3	66,066.0			
Зөвлөмж	1	9,478.6	1	9,478.6			
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>75,544.6</b>	<b>4</b>	<b>75,544.6</b>			

/мянган.төг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 49,722.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20,794.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,358.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 22,569.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шууд зардалд бүртгэсэн 19,386,4 мянган төгрөгийг бараа материалыг тооцооны дансаар дамжуулан тайлагнуулсан.
2. ХХОАТ-ын 1,408, 5 мянган төгрөгийг авлага, өглөгөөр бүртгүүлсэн.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар үйл ажиллагаатай холбоотой 6,358.5 мянган төгрөгийн зөрчилд 2, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 201,063.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос 1,408,505 төгрөгийн татвар суутган авсан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2-т "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



2. Сумын Засаг даргын захирамжаар нийт 4,950.0 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Хөрөнгийн 201,063,8 мянган төгрөгийн орлогыг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 22,569.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутгаан тооцсон байна. Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Дотоод хяналттай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй үлдэх өртөггүй, ашигладаггүй 1,201.0 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС - 17 мөрдөж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үндсэн хөөнгийн үлдэгдлийг ИТХ-аар оруулан засна. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### *2. Дотоод хяналттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 568.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.

2.2. Эрсдэл: Бодит зардал буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж СС-ын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### *3. Дотоод хяналттай холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт: Шилжүүлэн авсан цаашид ашиглах боломжтой 20,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийгээгүй байна.

3.2. Эрсдэл: Хөрөнгийн үнэ цэнэ алдагдах

3.3. Өгсөн зөвлөмж УСНББОУС - 17 мөрдөж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Булган сумын Засаг Даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			ДОА-2021/17/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		<b>Булган сумын Засаг Даргын Тамгын газар</b>	Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хууль зөрчин цалингаас суутган авсан татварыг авлага, өр төлбөрөөр бүртгүүлсэн.	1,408.5	Залруулга хийлгэсэн.	Нягтлан бодогч	Г.Амартайван
2	Шууд зардалд бүртгэсэн бараа материалыг тооцооны дансаар дамжуулан тайлагнуулсан.	19,386.4	Залруулга хийлгэсэн.	Нягтлан бодогч	Г.Амартайван
3	Сумын Засаг даргын захирамжаар тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан.	4,950.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амартайван
4	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан	1,408.5	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амартайван
5	Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй үлдэх өртөггүй, ашигладаггүй санхүүгийн программ хангамж байна.	1,201.0	Зөвлөмж өгөв	Нягтлан бодогч	Г.Амартайван
6	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.	568.1	Зөвлөмж өгөв	Нягтлан бодогч	Г.Амартайван
	Шилжүүлэн авсан цаашид ашиглах боломжтой тээврийн хэрэгсэлд дахин үнэлгээ хийх.	20,800.0	Зөвлөмж өгөв	Нягтлан бодогч	Г.Амартайван
	2 орлогын 13,680.0 мянган төгрөгийн, 4 зарлагын 37,514.5 мянган төгрөгийн гүйлгээг, 9 хөрөнгийн 149,869.3 мянган төгрөгийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.	201,063.8	Албан шаардлага	Нягтлан бодогч	Г.Амартайван
<b>ДҮН</b>		<b>250,786.3</b>			

